



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ ЖУРАМ, АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ /Ургамлын нөхөн төлбөрийг төлүүлэх журам, аргачлал/ 2011 оны 10 дугаар сарын 24-ны өдөр Улаанбаатар хот Дугаар:А-354 "Байгалийн ургамлын тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь: 1. "Ургамлын нөхөн төлбөрийг төлүүлэх журам, аргачлал"-ыг нэгдүгээр, "Ургамлын нөхөн төлбөрийн актын маягт"-ыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай. 2. Энэхүү журам, аргачлалыг мөрдөн ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, нийслэлийн Байгаль хамгаалах газар, аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай. 3. Энэ журам, аргачлалын хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага зохицуулалтаар ханган ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар /Д.Энхбат/-д үүрэг болгосугай. 4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Аргачлал батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А-156 дугаар тушаалаар баталсан "Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал"-ын хоёрдугаар бүлгийн 2.8 дахь хэсгийн "... экологи-эдийн засгийн үнэлгээ" гэсний дараа ; , хохирол" гэсэн үгийг хассугай. САЙД Л.ГАНСҮХ Улсын бүртгэлд 2011 оны 11-р сарын 09-ний өдрийн 3280 дугаарт бүртгэв.